

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН**  
**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-17
<hr/>	
<i>1.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийн болон ноос, ноолуурын боловсруулалтын талаар хяналт, шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл сонсоно</i>	4-15
<i>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/</i>	15-17

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны  
11 дүгээр сарын 29-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, С.Ганбаатар, Г.Дамдинням, Ц.Туваан;

Чөлөөтэй: Ц.Анандбазар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийн болон ноос, ноолуурын боловсруулалтын талаар хяналт, шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч Т.Нармандах, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, мөн газрын мэргэжилтэн В.Болормаа, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Б.Алтанцэцэг, мэргэжилтэн Ч.Октябрь, Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн С.Энхжин, Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Худалдааны хэлтсийн дарга Н.Энхцацрал, мэргэжилтэн Б.Баттуяа, Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн Г.Батзориг, мөн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны газрын ахлах мэргэжилтэн Д.Болормаа, Д.Төрмөнх, Хөдөө аж ахуйн биржийн Гишүүнчлэл, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн В.Мөнхнэмэх, мөн биржийн Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхзул, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ноос, ноолуур судлалын салбарын эрхлэгч Ц.Ганболд, мөн сургуулийн ахлах багш Д.Батбаяр, Монгол Солонгосын политехникийн коллежийн багш Ч.Цолмон, Монголын ноос, ноолуурын холбооны Баталгаажуулалтын албаны дарга Ц.Туяа, мөн албаны зөвлөх М.Мөнгөнбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Лхагвасүрэн, Д.Отгонбаатар нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийн болон ноос, ноолуурын боловсруулалтын талаар хяналт, шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн дэд сайд М.Ганхүлэг танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Т.Энхтүвшин, Г.Ганболд нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн В.Болормаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

**Г.Ганболд:** “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийн болон ноос, ноолуурын боловсруулалтын талаар хяналт, шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл сонслоо.

*Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын ахлах аудитор Б.Батдэлгэр, “Тавантолгой төмөр зам” ХКК-ийн гүйцэтгэх захирал Н.Будбаяр, мөн компанийн Төсөл, хөгжлийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны дарга Н.Мөнхсүрэн, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Отгонсүх, мөн компанийн Санхүүгийн хэлтсийн дарга Г.Өлзийбаяр, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга Х.Батсайхан, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Энхцог, Санхүүгийн хэлтсийн дарга Ц.Баяргэрэл, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Ганболд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

**Г.Ганболд:** “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 01 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 11 цаг 28 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 27 минут.

### **ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Ганболд:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж байна. Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Их Хурлын гишүүн Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Ганболд нар хүрэлцэн ирж хуралдааны ирц 56,2 хувьтай болж ирц бүрдсэн тул хуралдааны ажиллагаа нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн. 1 дүгээрт нь Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын борлуулалтын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн мэдээллийг сонсох. 2-т нь Монгол Улсын ЗГ-т чиглэл өгөх тухай Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх гэсэн ийм 2 асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад асуулт, саналтай гишүүн байна уу? Асуулт, санал байхгүй байна.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийн болон ноос, ноолуурын боловсруулалтын талаар хяналт, шалгалт хийж, холбогдох**

### **санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл сонсоно**

Хэлэлцэх асуудлынхаа төлөвлөгөөг баталъя. Ингээд хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн мэдээллийг сонсоно.

Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулаад ажлын хэсгийг танилцуулъя. Онончимэг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн ахлах зөвлөх, Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт, Отгонбаатар Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шалгалт үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт, Нармандах Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч, Ганхүлэг ХХААХҮ-ийн дэд сайд, Дондогдорж ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын дарга, Болормаа ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын ахлах мэргэжилтэн, Алтанцэцэг ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-ын ахлах шинжээч, Энхжин ХАА-н биржийн Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн, Мөнхзул мөн биржийн төлбөр тооцоо эрсдэлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, Мөнхнэмэх мөн биржийн Гишүүнчлэл, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Л.Энх-Амгалан Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Н.Энхцацралт Эдийн засгийн хөгжлийн яамны Худалдаа эдийн засаг хамтын ажиллагааны бодлогын газрын Худалдааны хэлтсийн дарга, Баттуяа Эдийн засгийн хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын худалдааны хэлтсийн мэргэжилтэн, Батзориг СХЗГ-ын Стандартчилал,

тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Д.Болормаа СХЗГ-ын Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Төрмөнх мөн газрын ахлах мэргэжилтэн, Ц.Ганболд ШУТИС-ийн Хөнгөн үйлдвэрлэлийн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн ноос, ноолуурын судлалын салбарын эрхлэгч, Батбаяр тус сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн ахлах багш, Туяа Монголын ноос, ноолуурын холбооны баталгаажуулалтын албаны дарга, Мөнгөнбаяр Ноос, ноолуурын холбооны баталгаажуулалтын албаны зөвлөх, менежментийн стандартын аудитор гэсэн ийм ажлын хэсэг байна.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос 2023 оны 5 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын боловсруулалтын түвшинийг нэмэгдүүлэхтэй холбоотой Улаанбаатар хот, орон нутагт хялгас ялгах аас дээш боловсруулалт хийх үйлдвэрүүдийн хүчин чадал, суурилуулагдсан тоног төхөөрөмжийн талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалаар ахлуулан байгуулсан. Мөн Байнгын хорооны 06 дугаар тогтоолоор энэ ажлын хэсгийг ажиллах удирдамжийг батлан Дэд ажлын хэсгийг ХХААХҮ-ийн дэд сайдаар ахлуулан байгуулж, Улаанбаатар хотод болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа энэ үйлдвэрүүдийн хүчин чадлыг бодит байдал дээр нь ажлын хэсэг очиж ажиллаж санал, дүгнэлт боловсруулах ийм чиглэл өгсөн. Ингээд ажлын хэсгийн танилцуулгыг ХХААХҮ-ийн дэд сайд Ганхүлэг танилцуул. Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье.

**М.Ганхүлэг:** Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсгийн дагуу бид бүхэн бас

хялгас ноолуурын хялгас ялгах буюу самнах дамжлагыг нэвтрүүлсэн 50 ААН-тэй бас очиж биечлэн танилцаж, тодорхой дүгнэлтийг гаргалаа. Үүнтэй холбогдолтой бас мэдээллийг та бүхэндээ танилцуулъя. Манай ажлын хэсэг нийтдээ 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурлын Тамгын газар, Эдийн засаг, хөгжлийн яам, ХХААХҮЯ, мэргэжлийн бас байгууллагууд ШУТИС, ХАА-н бирж зэрэг бүрэлдэхүүнийг нэг багт оруулаад ингээд 3 үндсэн баг болж бид бүхэн ажилласан. Нийтдээ яг 50 бас үйлдвэрээр бүтэн орж танилцсан. Үүний бол 45 нь бол нийслэл Улаанбаатар хотынх, 5 нь бол хөдөө орон нутгийн ийм бас ААН-үүд байлаа.

Ноолуурын зах зээлийн ерөнхий дэлхийн нөөц боломж ямар түвшинд байгаа вэ гээд гэдэг энэ агуулгаас танилцуулгаа эхэлье. Монгол Улс бол дэлхийн ноолуурын нөөцийн 2 дахь том бэлтгэгч ийм улс байгаа. Дэлхийн ноолуурын зах зээл дээр жилдээ 24 мянган тонн ноолуурыг бэлтгэдэг ийм судалгаа байна. Ноолуурын хувцасны буюу хамгийн сүүлийн шатад нийт зах зээлийн 3,3 тэрбум ам.доллар бас эргэлдэж байгаа нэлээн ийм томоохон зах зээл байгаа. Үүний дунд шат дамжлагууд дээр бас тодорхой бас мөнгөн төлбөрүүд бас эргэлдээд ингээд явж байгаа юм. 2400, 24 мянган тонн ноолуур бэлтгэхдээ бол БНХАУ ойролцоогоор 50 орчим хувийг, Монгол улсын хувьд бол 42 хувийг бол үндсэндээ хангаж байна. Тэгэхээр ноолуурын түүхий эдийн гол 2 тоглогчийн нэг нь Монгол Улс байгаа юм. Бусад улс бол бол Иран, Афганистан эдгээр улсууд нийлээд 8 хувийн түүхий эдийг нийлүүлж байна. Ноолуурын үйлдвэрлэлийн гол өрсөлдөгч Хятад улстай харьцуулахад бид бүхэн бол өнгөрсөн 2022 онд 9,7 мянган тонн ноолуур, Хятад улсын хувьд бол 15,4 мянган тонн ноолуурыг бас ноолуурын түүхий эд бэлтгэсэн байна гэдэг ийм судалгааг бол эндээс харж болохоор байгаа юм.

Тэргүүлэх экспортлогч улс орнуудын хувьд бол угаасан ноолуурыг экспортоороо Монгол Улс бол жилд 307,9 сая долларыг бол бид бүхэн бас экспортолж байна. 2-т бол БНХАУ орж байгаа юм, 3-д нь бол Итали улс орж байгаа юм. Самнасан ноолуур болоод ирэхээрээ БНХАУ, үүнээс 480 сая долларыг, Монгол Улс бол 93 сая долларыг бол олж байгаа ийм үзүүлэлт байна. Тэргүүлэгч импортлогч эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор авч байгаа угаасан ноолуурыг бол БНХАУ манай улсаас бол дийлэнх ноолуураа бол аваад ингээд дараагийн шатын үйлдвэрлэлүүдээ хийж байна. Самнасан ноолуур дээр бол Итали улс бол хамгийн их хэмжээгээр авч байна. БНХАУ-ын хувьд бол ноолууран эдлэлийн гол үйлдвэрлэгч дэлхийн нийт үйлдвэрлэлийн 60 хувийг бол эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж байна. Итали, Их Британи, АНУ бол дэлхийн хамгийн алдартай ноолууран бүтээгдэхүүний брэндүүд байршдаг ийм статистик мэдээллүүд байна.

Монгол Улсын хувьд нөөц бололцоо боловсруулсан ноолуурын экспорт бол сүүлийн жилүүдэд сэргэж байгаа. Бид бүхний бас 2022 онд гарсан Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоол батлагдсанаас хойш тодорхой бас үр дүнгүүд харагдаж байгаа юм. 2020 онд бид бүхэн 185 сая долларыг угаасан ноолуураас, самнасан ноолуурыг бид бүхэн 17 сая долларыг олдог байсан бол 2022 онд бид бүхэн самнасан ноолуурын экспорт 93 сая доллар болж бас нэмэгдсэн байгаа юм. Угаасан ноолуурын экспорт 308 сая болж байгаа юм. 2023 оны эцсийн дүн бол арай гараагүй, 2023 оны 10 сарын байдлаар 254 сая долларын угаасан ноолуур, 97 сая долларын самнасан ноолуурыг бид бүхэн экспортод гаргаад байна. Мөн оны үетэй харьцуулахад угаасан ноолуурын экспорт бол буурсан. Самнасан ноолуурын экспорт бол нэмэгдэх ийм хандлагатай байгаа юм. Анхан шатны боловсруулалт хийсэн ноолуурын экспортыг угаасан болон самнасан шат дамжлагаар нь

ангилаад үзэхэд Монголчууд бид бүхэн угаасан ноолуураа 99,9 хувь буюу ер нь 100 хувь БНХАУ руу экспортолж байна. Мааш бага хэмжээгээр судалгааны зорилгоор Энэтхэг болон бусад улсууд руу бол гаргасныг эс тооцвол ингээд 100 хувь бид бүхэн угаасан ноолуураа Хятад руу бас гаргаж байгаа юм.

Самнасан ноолуур болох энэ шат дамжлагыг нэмэгдүүлсний хамгийн эхний боломж нь бид бүхний экспортын улсууд маань бол нэмэгдэх боломж бүрдэж байгаа юм. Зөвхөн бид БНХАУ руу биш Итали, Их Британи, БНСУ болон бусад улс орнууд руу самнасан ноолуураа экспортлох энэ боломжууд бол бий болно. 93 сая ам.долларын самнасан ноолуурыг бид бүхэн 86,2 хувийг нь бол Итали руу, Их Британи руу бол 8,5 хувийг нь, БНСУ руу бол 3,7 хувийг нь бид бүхэн экспортолж байна. Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн экспортын хувьд бол нийтдээ 51, 50 ААН байгаа, угаасан болон самнасан ноолуураар нь бид бүхэн бас ингээд задлаад доор бас гаргаж ирсэн байгаа. Сүүлийн жилүүдэд бол ААН-үүд маань энэ самнасан ноолуурыг экспортод гаргах энэ суурь техникийн зохицуулалтууд нь бол бий болоод, тодорхой хэмжээгээр угаасан ноолуурын экспорт багасаж, самнасан ноолуур өсөх энэ боломжууд бас бүрдэж байгаа юм.

Монгол Улс самнасан ноолуурын экспорт Бүгд Найрамдах Хятад улстай бас харьцуулж байгаа юм. Манай ер нь гол импортлогч улс бол Итали улс байгаа. Монгол Улсын хувьд бол угаасан ноолуураа 100 хувь Хятад руу экспортолоод, тэндээс бол.../үг тасрав/

**Г.Ганболд:** Яг хяналт шалгалтынхаа сэдвийн дагуу яримаар байна. Яг хэдэн үйлдвэр дээр очсон юм, яг нөгөө суурилуулагдсан хүчин чадал тэрийгээ л ярь. Эд нар экспорт энэ олон юмнуудыг яриад хэрэггүй.

**М.Ганхүлэг:** Ойлголоо.

**Г.Ганболд:** Яг сэдэв чинь тодорхой шүү дээ. Тэрэн дээр ерөөсөө яг тодорхой юмнуудаа яриадах, хэдэн үйлдвэр дээр та нар очсон юм, хүчин чадал чинь яг хэд байгаа юм тэгээд л тэрийгээ л ажлын хэсэг баталгаажуулах юмаа ярь.

**М.Ганхүлэг:** Тийм, тийм. Манайхаас авсан ер нь яах вэ би товчлоод танилцуулчихъя. Манайхаас угаасан ноолуур аваад БНХАУ-ын хувьд бол дараагийн шат дамжлагуудыг хийгээд, Итали улс руу болон Европын орнууд руу гаргаад байгаа энэ бас давуу байдал бий болоод байгаа юм. Бид бүхэн бол яг түүхий эдийн 40-өөс 45 хувийг бол дангаараа нийлүүлж байгаа хэр нь үүнийгээ бол бас боловсруулахгүйгээр ингээд өгч байгаа нь бусад улсуудад бас давуу байдал олгоод байгаа гэдгийг эндээс бол харж болохоор байгаа юм.

Үндсэндээ ноолуурын шат дамжлага дээр бол угаах чиглэлийн 34 үйлдвэр Монголд байна. Хялгас ялгах 50 үйлдвэр, ээрэх 16, сүлжих бол 14 ийм цогц үйлдвэр, ЖДҮ-лэлийн бол 80 ААН байгаа юм. Үүнээс бид бүхэн хялгас ялгах 50 ААН дээр ажлын хэсэг бол ажилласан. Ажлын хэсгийн үндсэн дүгнэлтээр суурилагдсан хүчин чадал бол 11934 тонн ийм самнах хүчин чадал бол суурилагдсан байна гэдэг дүгнэлт гарсан байгаа. Үүнээсээ бол ноос самнах үйлдвэрлэлээ бол хасахаар ноолуур самнах боломжит хүчин чадал маань бол 8530 тонн байгаа юм. Энийгээ бол анхан шатын түүхий ноолууртайгаа харьцуулаад үзэхэд 17050 тонн ийм түүхий ноолуурыг үндсэндээ бол бид бүхэн самнах бүрэн хүчин чадал суурилагдсан байна гэдэг энэ дүгнэлт гарч байгаа юм. ААН-үүдийн хувьд бол нийтдээ 50 үйлдвэрийн 39 үйлдвэр нь бол дотоодын үйлдвэрлэлүүд байна. Гадаад улсын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд бол БНХАУ-ын 8 компани, Итали улсын 2 компани, Япон улсын 1 компани байна. Жишээ нь гэх юм бол БНХАУ-ын 8 компани 2 мянга, үүний 6 нь бол өмнө нь угаасан ноолуур экспортод гаргаж байсан. Нэмэлтээр бол 2 компани

нэмэгдээд эдгээр 8 компани бол 2023 оноос самнасан ноолуур экспортод гаргах хүчин чадлыг 3380 тонноор нэмэгдүүлсэн ийм суурилуулсан байна. Тэгэхээр энэ техникийн зохицуулалттай холбогдолтойгоор гаднын хөрөнгө оруулагчид манай дээр тодорхой энэ самнах дамжлагын үйлдвэрүүдийг бас барьж ашиглалтад оруулах энэ чиглэлийн ажлууд бас нэлээдгүй хийгдсэн байгаа нь эндээс харагдаж байгаа юм.

Дотоод, дотооддоо бол бид бүхэн самнах дамжлагын 50-иас илүү хувийг бас өөрсдөө суурилуулсан байна. Бас гаднын үйлдвэрүүд бол нэлээдгүй бас орж ирээд ингээд ажиллаад байгаа гэдэг ийм хардлагууд бас байгаа. Гэсэн хэдий боловчиг дотоодын 39 үйлдвэр үндсэндээ бол энэ самнах дамжлагыг бий болгосон байна. 2022, 2023 онуудад шинээр 15 үйлдвэрт 4163 тонн хүчин чадал бол нэмэгдсэн. Үүнээс 2022 онд 3 ААН, 2023 онд бол 12 ААН бол үндсэндээ бол нэмэгдсэн. Тэгэхээр техникийн зохицуулалтыг нэлээн хүлээсэн энэ батлагдсанаас хойших энэ ААН-үүд бол нэлээн эрчимжсэн тоног төхөөрөмжөө шинэчлэх суурилуулах ажлууд бол үүнтэй уялдаж шууд хамааралтайгаар явж байгааг эндээс бас харж болохоор байгаа юм.

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлын хувьд бол Монгол Улс 10 мянган тонн ноолуурыг үндсэндээ бол бэлтгэж байгаа. Угаасан ноолуур болгоод бол бид бүхэн долоон мянган тонн ноолуурыг бол экспортод гаргаж байна. Ойролцоогоор бол 335 сая долларыг бид бүхэн жилд эндээс олж байгаа юм. Одоогийн бид бүхний хүчин чадал бол угаасан ноолуур бэлтгэх дээр бол хангалттай байгаа. Самнасан ноолуурын хүчин чадал 4900 тонн. Бид нарын саяын гаргасан 8 мянга орчим гээд энэ тооцоо бол бид бүхний одоогийн байгаа нөөцөөс илүү бас, юу 2 дахин нэмэгдсэн ийм суурилагдсан хүчин чадал байна гэдэг ийм тооцоолол байгаа. Тодорхой бас хүний нөөц болон бусад эргэлтийн хөрөнгийн бас тодорхой



дүгнэлтүүдийг ажлын хэсэг гаргасан байгаа. Хэрвээ бид бүхэн самнасан бүх ноолуураа самнаад гаргах юм бол жилдээ 476 сая долларын экспортыг хийх бүрэн боломж бас бид бүхэнд байгаа юм.

Энгийнээр хэлэх юм бол бид нар 2023 оны 10 сарын байдлаар нийтдээ бол 250 аравны 50 сая, 5 сая долларыг бол угаасан ноолуураас олсон. 1кг ноолуурыг 47,9 сая доллароор бид бүхэн экспортод гаргаж байгаа юм. Хэрвээ самнаад гаргах юм бол 97,2, 97 доллар болгож өсөх 2 дахин бас өсөх ийм бас боломж байгаа юм. Тэгэхээр энэ ноолуурын салбарын зах зээлээ 2 юу хувь, 2 дахин өсгөх энэ боломжийн тухай бид бүхэн бас яриад байгаа юм. Цаашидаа ээрэх бол ноолууран эдлэл болгож гаргах энэ бололцоонууд бол байгаа. Тэгэхээр 1,5 тэрбум долларын энэ боломжийг бид бүхэн дотооддоо үйлдвэрлэх боломж байгаа юм гэдгийг эндээс харж болохоор байна. Хялгас ялгах энэ юу 50 үйлдвэрийн бол 45 нь Улаанбаатар хотод, 5 нь бол орон нутагт байгаа. Өөрсдөө бол угаах энэ дамжлагыг суурилуулсан 25 үйлдвэр байсан, ээрэх 7 үйлдвэр, эцсийн бүтээгдэхүүн энэ 50 үйлдвэрийн маань 13 нь бол үйлдвэрлэж байна. Нийт ажиллагсад зөвхөн хялгас ялгах аас бусад шат дамжлагууд бүгдээрээ ороод 4220 ажилтан үүн дээр ажиллаж байна. Эрэгтэй, эмэгтэйгээр нь ороход 70 орчим хувь нь бол эмэгтэй ажилчид байгаа юм. Үндсэн ажилчид бол 3872, гэрээт ажилчид 347 байгаа. Үүнээсээ яг зөвхөн хялгас ялгах дамжлага дээр ажиллаж байгаа 2200 ажилтан байна. Шаардлагатай яг өнөөгийн юу хүний нөөцийн хувьд бол 1584 ажилтан шаардлагатай байна. Цаашидаа 100 хувь хялгас ялгах энэ дамжлагыг нэвтрүүлэхэд 4400 орчим ажиллах хүч шаардлагатай байгаа юм. Нарийн мэргэжлийн бол 380, мэргэжилтэй ажилтан 1200 байгаа. Хүний нөөцийн хувьд бол заавал ч үгүй нарийн мэргэжлийн боловсон хүчин гэхээс илүүтэй энгийн бас ажиллах хүчнийг сургаад ингээд ажиллах бас бүрэн

боломжтой ийм салбар гэдгийг бас би бас онцолж хэлье.

Одоогийн нийт хүчин чадлын хувьд бол хялгас ялгах үйлдвэрлэлийн 36,1 хувиа бид бүхэн ашиглаж байна. Үүнийг цаашидаа бол нэмэгдүүлэх энэ зохицуулалтууд бол шаардлагатай. Үүний хүрээнд бол бид бүхэн төрөөс тодорхой бас зээлийн дэмжлэгүүдийг бол үзүүлсэн, явуулаарай. 2021 онд 15 ААН-д 69,7 тэрбум, 22 онд 15 ААН-д 106,9 тэрбум, 23 онд 16 ААН-д 134,4 тэрбум төгрөгийн энэ санхүүжилтүүдийг хийсний үр дүнд өнөөдрийн хүчин чадал суурилагдсан байгаа юм. Энэ бол зөвхөн төрөөс үзүүлсэн дэмжлэг байгаа. Тийм. Бусад гаднын болон энэ хөрөнгө оруулалтууд бас нэлээдгүй хийгдсэн байгаа юм. Тийм.

Ажлын хэсгийн тодорхой 3 дүгнэлтийг бид бүхэн гаргаж ирсэн байгаа. Хамгийн 1 дүгээрт хүний нөөцийн дутагдалтай байгаа энэ асуудал дээр тусгайлсан бодлого хэрэгжүүлбэ. Тухайлбал мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн ТУЗ-д ноос, ноолуурын компанийн төлөөллүүдийг оруулъя. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Политехникийн коллеж, одоогийн суралцаж байгаа Шинжлэх ухаан технологийн их сургуулийн суралцагч нарыг тухайн компаниудтай бас шууд дадлагажих хамтарсан ийм хөтөлбөр байдлаар зохион байгуулъя. Цаашидаа энэ ТУЗ-д төлөөлөл орсноороо салбарын энэ хүний нөөцийн бодлого дээрээ өөрсдийнхөө санаа бодлыг тусгаад, ингээд ажиллаад явах боломж нь бүрдэнэ гэж харж байгаа юм.

2 дахь асуудал бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа хамгийн чухал асуудал бол эргэлтийн хөрөнгийн асуудал байгаа юм. Тэгэхээр энэ эргэлтийн хөрөнгийн асуудал дээр бас тодорхой ЗГ-ын баталгаа гаргаж, урт хугацаатай болон хөнгөлөлттэй энэ бас зээлүүдийг олгох чиглэлээр ААН-үүд маань бас санал дэвшүүлсэн. Ингээд

Улаанбаатар хотод байрлах 45, орон нутагт байрлах 5, нийт 50 хялгас ялгах үйлдвэрт 11964 тонн самнах, самнасан ноолуур гаргах бүрэн хүчин чадал суурилагдсан. Үүнээс бол 8530 тонн нь бол самнасан ноолуурыг гаргах боломжит хүчин чадал байна. Ингээд боломжит хүчин чадлыг түүхий ноолуурт шилжүүлж тооцох юм бол 17 мянган тонн, түүхий ноолуурыг самнах боломжтой байгаа. Иймд ЗГ-ын баталсан техникийн зохицуулалтыг заасан хугацаанд хэрэгжүүлж үргэлжлүүлэх энэ саналыг ажлын хэсгээс оруулж байгаа юм.

**Г.Ганболд:** Дэд ажлын хэсгийн дарга Ганхүлэг сайдад баярлалаа. Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух Байнгын хорооны гишүүд нэрсээ өгье. Өөр асуулт асуух гишүүн, Энхтүвшин гишүүн дараад байна уу, үгүй юү? Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Тэмүүлэн гишүүний гишүүн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Ямар ч бай ажлын хэсэг бас сайн ажилласан байна. Ерөнхий бид нарт ойлгомжгүй байсан, тодруулах шаардлагатай асуудлуудыг бас нэлээн нарийвчилж гаргаж ирсэн байна. Би зүгээр яах вэ тодорхой саналаа хэлээд л явчихъя гэж бодоод байна. Энэ дээр бид нар ингэсэн юм, одоо их, Улсын Их Хурлын 2022 онд гаргасан 19 дүгээр тогтоол байгаа. Энэ тогтоолтой холбогдуулаад сая ЗГ болоод Улсын Их Хурлаас Байнгын хорооноос ажлын хэсэг ажиллаад дахиад ЗГ-т чиглэл өгөх Байнгын хорооны тогтоол тогтоолын төсөл оруулж ирж байгаа юм Ажлын хэсэг. Тэгэхээр Байнгын хорооноос гарах энэ тогтоол маань 2 заалттай. Би бол яах вэ тогтоолынхоо агуулга дээрээ бид нар нэг жоохон илүү тодруулж өгөөд, цаг хугацаагаар нэлээн ЗГ-ыг шахаад ингээд ажиллах шаардлагатай гэж хараад байгаа юм. 2022 онд бид нар энэ 19 дүгээр тогтоолыг гаргахад нэлээн их ажил болж байж Байнгын хорооноос хэд хэдэн гишүүд санаачилж байж энэ хууль маань Улсын Их Хурлын босгыг даваад

ингээд батлагдсан. Энэ тогтоолын хэрэгжилт үндсэндээ одоо байхгүй болчихоод байгаа юм. Яах вэ нөгөө талдаа яах вэ гол би зүгээр том агуулгаараа л байхгүй болчихоод байна гэж хэлээд байгаа болохоос биш мэдээж төрөөс бид нар энэ боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, үе шаттайгаар хялгас ялгах шат руу ахих, үүн дээр ААН байгууллагууд дээр татварын хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, боловсруулалтынх нь үйлдвэрийн хүчин чадлуудыг нэмэгдүүлэхэд, тоног төхөөрөмжийг нь оруулж ирэхэд төрөөс бодлого, санхүүжилт татвараар дэмжих гээд энэ бодлогууд бол мэдээж хэрэгжсэн.

Би юу хүсээд байна вэ гэхээр энэ үйлдвэрлэл худалдааны техникийн зохицуулалтыг баталж мөрдүүлэх гэдэг ерөөсөө л 2029 оны, 22 оны 19 дүгээр тогтоолын 1 дүгээр заалт л байгаад байгаа юм. Ерөөсөө л 1 дүгээр заалтын энэ л ач холбогдолтой. Энэ хэрэгжээгүй одоо бараг ингээд жил хагас болоод 2 дахь жил рүүгээ ингээд орох гээд явж байна. Тун удахгүй 24 он гарлаа. Тэгэхээр та бүхний энэ үзүүлсэн танилцуулга мэдээлэл ч гэсэн ерөөсөө бид нарт суурилагдсан хүчин чадал хангалттай болчихсон. Нэг ч гэсэн хоногийн өмнө бид нар энийг бүрэн хэрэгжүүлэх, хялгас ялгах, илүү түүхий ноолуур гаргах асаа илүүтэй 2 дахин нөөц боломж бололцоо байна гэдгийг чинь бол тодорхойлж гаргаж ирээд байгаа юм. Тэгэхээр одоо үндсэн ажил руугаа л би орёе гэх гээд байгаа юм. Одоо ЗГ-т энд дахиад Их Хурлын тогтоолоос давсан Байнгын хорооны тогтоол ч гэж бас юу байх вэ. Тэгэхээр би энэ дээр бүүр тодотгож үнэхээр оруулъя гэвэл 24 оны намрын ээлжит чуулганы хугацаанд буцаагаад танилцуулахыг ЗГ-т, нөгөө 22 оныхоо тогтоолын хэрэгжилтийг шахаж шаардаад байх би шаардлагагүй гэж хараад байгаа юм. 23 оны намрын ээлжит чуулган 1 сард, 1 сарын сүүлээр дуусна. Тэгэхээр магадгүй 2 сарын хугацаатай үүрэг даалгаврыг ЗГ-т өгөөд, 24 оныг нь 23 оны намрын ээлжит чуулган болгоод ингээд оруулж ирээч.

Энэ даалгаврыг чинь бид нар өмнө нь өгчихсөн. Баталж мөрдүүлэх гэдэг асуудлуудыг, цогц бодлого оруулж ирэх гэдэг асуудлыг бас өгчихсөн.

Тэгэхээр ерөөсөө одоо бид нарын хувьд болбол ЗГ 22 оны тогтоолын 1 дүгээр заалт буюу худалдааны техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, эргээд энэ суурилагдсан хүчин чадал буюу экспорт худалдааныхаа бодлого дээр дүрэм журам дээр өөрчлөлтүүдээ оруулаад ингээд нэг ч гэсэн хоногийн өмнө бид нар энийг мөрдүүлж эхлэх зайлшгүй шаардлагатай байна. Энэ ЗГ-ын Улсын Их Хурлын тогтоол 22 онд тогтоол хэрэгжиж эхлэхгүй юм болбол үндсэндээ бид нар мянга Улсын Их Хурлаас мөнгө төгрөг гаргаад, дахиад 2 дахь тогтоол гаргаад үр дүнгүй болох гээд байна шүү дээ. Ингэж байж л бид нар эдийн засгийнхаа бие даасан байдал, хараат бус байдлыг, үндэсний үйлдвэрлэлийгээ дэмжих энэ бодлого чинь л хэрэгжиж эхлэх гээд байгаад байгаа юм. Тэгээд хэдий болтол хүлээх юм бэ? 23 онд сонгуулийн өмнөх жил гээд хүлээлгэсэн. Одоо бэлэн нөөц бололцоо байна бид нарт, энэ дээр болбол алдаад оноод байх зүйл байхгүй. Тэгэхээр би болбол цаг хугацаа дээр нь дахиад 2 сарын хугацаатай өгье, дахиж жил хойшлуулаад байх би шаардлага байхгүй л гэж харж байгаа.

**Г.Ганболд:** Батжаргал гишүүн хариулъя. Батжаргал гишүүний микрофоныг өгье, ажлын хэсгийн ахлагч.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр ноолуурын боловсруулалтын түвшний суурилагдсан хүчин чадал бүх юмнуудаа дүгнээд үзчихсэн, бололцоо байна. Гэхдээ боловсруулалт хийхэд дан ганц суурилагдсан хүчин чадал биш, энд олон хүчин зүйл байгаад байгаа юм. Хүний нөөцийн асуудал байгаад байна. Мэргэжлийн боловсон хүчин, мэргэжлийн ажилчдын асуудал байгаад байна. Бараг үндсэндээ энэ 8500 тонн суурилагдсан хүчин чадлыг ажиллуулъя гэвэл ажиллах хүчнийх нь нөөц дахиад 50

хувиар нэмэгдэж байж сая энэ өөрөө бүтэн эргэлтэд орох бололцоо байгаа. Дээр нь бас тодорхой санхүүгийн эх үүсвэр энэ тэр гээд тодорхой асуудлууд байна. Үүнийг иж бүрэн судалж үзсэн юм. Тийм учраас би энэ 1 дүгээр заалтаар ЗГ тэр баталсан бараа, бүтээгдэхүүний тэр б...сынхаа хэрэгжих хугацааг мөрд гэдэг ийм заалт өгчих нь зөв юм байна гэж 1. 2 дугаарт ерөөсөө дэлхийн зах зээл дээр энэ ноос, ноолуурынхаа салбарын өрсөлдөх чадварыг хангах цогц арга хэмжээгээ ав гэдэг зүйл байгаад байгаа юм байна. Тэгээд тэр 2 дахь заалтаар үндсэндээ одоо энэ ажиллах хүчнийхээ нөөцийн асуудлыг их зохистой зөв шийдэх тухай асуудал байгаа юм байна. Ийм байдлаар үүрэг өгье гэж 1.

2 дахь зүйл яагаад 24 оны намрын чуулган гээд хэлчхэв гэхээр зэрэг бид тухайн жилийн ноолуурын бэлтгэлт, боловсруулалт, экспортын түвшин бараг дуусаж байх үед энэ асуудал явагдаж байгаа байхгүй юу. Тэгээд одоо дараагийн юм ярьж гэвэл дараа оны энэ ажлууд нь яваад, үр дүн нь ямархуу байдалтай байгаа юм гэдгийг харах түвшиндээ л бид сонсох нь зөв. Угаасаа 1 дүгээр заалтаараа бид тэр гаргасан шийдвэрээ мөрд гээд үүрэг өгчхөж байгаа учраас энэ хүрээнд ер нь ямар үр дүн юу бий болов гэдэг юмыг сонсох л гэж байгаа бол одоо наана нь сонсох боломж байхгүй. Яг энэ мэдээлэл буцаж орж ирнэ. Өөр асуудал байхгүй болчхож байгаа байхгүй юу. Тийм учраас цаг хугацааны ч хувьд тэр, бэлтгэл зохион байгуулалтаа хангах хүрээнд ч тэр, бодлогын шийдлээ тогтвортой байлгах хүрээнд ч тэр, цаг хугацаа нь ч тэр, өгч байгаа чиглэл нь ч тэр ийм л зорилт л гарах юм байна л гэж ажлын хэсэг дээрээ ярьж тохирсон гэдгийг хэлье.

Угаасан ноолуур дэлхийн зах зээл дээр 45 доллар килограмм нь, самнасан 97 доллар. Тэгэхдээ бид угаасан 1,4кг ноолуурыг самнахаар 1кг болж байгаа. Тийм учраас үндсэндээ 63 орчим долларын 1,4кг ноолуурыг самнаад 97

долларын өртөг бүхий 1кг ноолуур гаргаж авч байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зөрөө, тэрнээс энэ хоёрын хоорондох зөрөө буюу 34 орчим доллар нь бид нарын боловсруулалт тэр ноолуур гэж хэлээд байгаа юмны чанарынх нь мөн чанарыг илтгэж харуулж чадаж байгаагийн илэрхийллээр л өсөж байгаа ийм л зүйл байгаад байгаа. Дээр нь түрүүн Монголын тэр түүхий ноолуур 308 сая долларын түүхий ноолуур Хятад руу гарчхаад, тэгээд Хятад, Итали руу 3,4 мянган тонн буюу 400 хэдэн сая долларын самнасан ноолуур экспортлохгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бидний зах зээл бэлэн байна л гэсэн үг. Тэгэхээр одоо үүнийгээ алдах юм уу, алдахгүй юм уу гэдэг асуудал бидний их том бодлого байгаа. Тийм учраас энэ мэдээллийг зориуд ингэж хооронд нь авцалдаатай бас энэ дэлхийн зах зээлийнх нь орчил эргэлтийг нь харьцуулж харуулах гэж л оролдсон. Тэгээд ойлгомжтой болох болов уу л гэж бодоод байна.

**Г.Ганболд:** Тэмүүлэн гишүүн тодруулъя.

**Г.Тэмүүлэн:** Тийм. Ойлгоод байгаа. Би тэгээд яах вэ зүгээр гол яах гээд байгаа юм чинь энэ худалдааны техникийн зохицуулалтыг бид нар хэзээнээс мөрдүүлж эхлэх юм бэ гэдэг асуудал болчихоод байгаа юм. Тэгэхээр одоо дахиад л 24 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуул гэхэд 24 онд жилийн дараа дахиад яг энэ өнөөдөр танилцуулсан танилцуулга чинь ЗГ-аас орж ирээд ингээд нэг магадгүй 26, 7 он болоод ч юм уу ингээд л явчих вий дээ л гэсэн болгоомжлол байгаад байгаа юм. Тэгэхээр би зүгээр биелэлтээ эхлээд эсвэл яах гэж байгаа төлөвлөгөө гэдэг юм уу эсвэл энэ тогтоолын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ ядаж ойрын хугацаанд танилцуулаад бид нарын бодлого ийм байгаад байгаа юм. Үнэхээр тийм байгаа бол боловсон хүчнээ бэлтгээд бид нар 25 оны 1 сарын 1-нээс гэдэг юм уу, 26 1 сарын 1-нээс гэдэг юм уу ингээд тунхаглаад зарлах хэрэгтэй

болчихоод байгаа байхгүй юу. Эсвэл бид нарын тогтоол дээрээ худалдааны техникийн зохицуулалтыг, тэрнээс тэрний дотор гэдэг юм уу хугацааг нь тодорхой зааж өгөөд ингээд мөрдүүлэх арга хэмжээг нь цаг хугацаатай нь шахаад явбал яасан юм бэ? Тэгэхгүй болбол бид нар 22 онд л энэ техникийн зохицуулалтыг баталж мөрдүүл гээд заагаад өгчихсөн.

**Г.Ганболд:** Батжаргал гишүүн хариулъя.

**Ж.Батжаргал:** 23 оны 7 сарын 1 гэсэн техникийн зохицуулалтыг 24 оны 7 сарын 1 гэж сунгалт өгсөн тийм биз ЗГ. Тэгэхээр одоо энэ л хугацаагаа барь л гэж байгаа юм ерөөсөө 1 дүгээр заалт. Одоо илүү, дутуу хугацаа яриад энд юу яагаад байх шаардлагагүй юм байна. Тэр тогтсон хугацаагаа мөрдөж ажилла л гэдэг ийм л чиглэл. Тэгээд яаж ч шийдвэр гарсан буцъя гэвэл буцна л даа энэ чинь тогтчихсон юм тогтсоноороо л.../үг тасрав/

**Г.Ганболд:** Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Г.Энхтүвшин:** Баярлалаа. Би мөн ялгаагүй дээ, Тэмүүлэн гишүүнтэй адилхан л байр суурийг л бол илэрхийлж байна. Байнгын хорооны тогтоолыг илүү их тодорхой гаргавал яасан юм бэ гээд. Тухайлбал юу гэдэг юм хэдэн ажлын байр бий болох юм, ААНБ-д хэдийнээс эхэлж хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлбэл бололцоо боломжтой юм, хэдэн сарын хэднээс эхлүүлээд одоо юу гэдэг юм энэ Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах юм гэдэг дээр бас тодорхой заалтуудыг өгөөд явчихвал их тодорхой юм болов уу гэсэн ийм бодолтой байгаад байна. Тэгээд энэ тогтоолыг хараад байхаар одоо юу гэдэг юм дахиад хэрэгжилтийг нь танилцуулаад, дахиад юу гэдэг юм нэг ажлын хэсэг ажилладаг ч гэдэг юм уу, дахиад л ингээд л цаашаа үргэлжлүүлээд явах л нэг ийм тогтоолын

төсөл байна. Тийм учраас тодорхой болгож оруулж ирвэл яасан юм бэ?

Энэ 2024 оны юу гэдэг юм дөрвөн, 1 сарын 1-нээс хэрэгжүүлдэг ч гэдэг юм уу, нөгөө Улсын Их Хурлын тогтоолоор гарсан ноос, ноолуурын боловсролтын түвшнийг нэмэгдүүлэхтэй холбоотой нөгөө хялгаснаас дээших боловсруулалт хийж байгаа ийм заалттай оруулаад явбал яасан юм бэ л гэсэн ийм байр суурийг л илэрхийлж байгаа юм. Ер нь энэ ХААЯ-наас асуухад яг одоо юу гэдэг юм ингээд Улсын Их Хурлын 2019 дүгээр, 22 оны 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээд явахад хэдэн ажлын байр бий болох юм, хэдэн ажлын байр бий болох юм бэ? 2 дугаарт юу гэдэг юм бас хууль гарсан шиг санаад байх юм. Энэ ХАА-н тоног төхөөрөмжийг оруулж ирэхэд гаалийн болон импортын татвараас 100 хувь чөлөөлөгдөж байгаа байх тийм ээ. Тэгээд хөнгөлөлттэй зээл ер нь хэчнээн ААНБ-д, хэчнээн тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олговол малчдаас авч байгаа ноолуурын үнэ нь буурахгүй байх ийм бололцоо боломж байгаа юм бэ, тийм судалгаа байгаа юм уу гэдэг дээр нэг хариулт хэлж өгөөч.

**Г.Ганболд:** Батжаргал гишүүн хариулъя.

**Ж.Батжаргал:** Судалгаа бүх юм хийхээр зэрэг энэ 50 үйлдвэр 6,1 мянган тонн түүхий ноолуур бэлтгэж авсан байгаа юм. Тэгээд эх үүсвэр талдаа болохоор зэрэг 131,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл л авсан байгаа. Тэгэхээр 6,1 мянган тонн ноолуур гэдэг бол 720 орчим тэрбум төгрөг өнгөрсөн жилийн ноолуурын дундаж үнээр тооцвол. Тэгээд бодохоор зэрэг энэ нөхдүүд 600 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэрээ өөрийн болоод гадаад захиалагчдынхаа урьдчилгаа төлбөр гэдэг юм уу үүн дээрээ тулгуурлаад хангаж чадсан байна гэсэн ийм л дүгнэлт гарч ирж байгаа. Энэ хэдийг би нарийсгаж нэлээн судлаад ер нь яг тухайн энэ жилийн ноолуур бэлтгэлтэд Монголын талаас хөнгөлөлттэй эх

үүсвэрийн эргэлтийн хөрөнгийн дэмжлэгт ер нь ямар юм гарвал их зохилтой байж болох юм гэдэг юмыг илүү тодруулаадхаарай гэсэн материал нь байгаа учраас би тодруулчихна байх гэж ингэж ойлгож байна.

Одоо энэ улсуудын яриад байгаагаар 1600 орчим ажиллах хүчний хэрэгцээ шаардлага байна гэж байгаа. Самнахаас дээш, самнах хүчин чадлаа бүрэн ажиллуулъя гэвэл 4400 ажлын байр яг бий болох юм гэсэн ийм л тов тодорхой тооцоо л гарч ирж байгаа. Тийм учраас энэ тооцоо судалгаа бүх юмнууд нь байна. Тийм учраас тэр ноос, ноолуурын салбарын өрсөлдөх чадварын тухай асуудал, тэгээд тэр хүний нөөцийг бэлтгэх тухай асуудал хоёулаа тогтоолын заалтад орчихсон учраас би их тодорхой юм уу л гэж ойлгоод байгаа шүү дээ. Энэнээс илүү их тодорхой юм ЗГ-т чиглэл өгсөн дорвол тодорхой утга агуулга бүхий чиглэлийг нь цогцоор нь авч хэрэгжүүл гэдэг байдлаар нь өгчих нь зөв юм байх л гэж ойлгож байгаа.

**Г.Ганболд:** Энхтүвшин сайд, гишүүн болсон уу тийм ээ? ХААЯ 3, ажлын хэсгийн 3 номер нэмэлт тайлбар хэлье.

**М.Ганхүлэг:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ажлын байрны хувьд бол сая бол хэлсэн. 4400 ажлын байр гэдгийг бол манай ААН-үүд болон холбооноос бас ерөнхий нарийвчлан судалгаа аваад өгсөн. Сая бас бид бүхэн явахдаа бас тодорхой энэ чиглэлийн судалгаануудыг авч баталгаажуулсан. Тэгээд энэ бол яг үндсэн ажилтан байгаа. Үүнээс гадна бас гэрээт тодорхой 1000-1500 орчим ажилтан ажиллах хүчин тухайн улирлын чанартайгаар бас орж ирж ажиллах боломж нь бүрдэнэ. Эдгээр хүмүүсийн нийгмийн даатгал бусад бас төлбөр мөнгөнүүд дотоодын бас эдийн засагт нэлээн том бас хувь нэмэр оруулах боломж нь бүрдэнэ. Яг одоогоороо бас ажлын байр дутагдалтай байгаа. Тэгэхээр 1500 орчим бас ажиллах ажлын

байр одоогоор дутуу байна. Үүний бол 400 гаруй нь бол нарийн мэргэжлийн, үлдсэн нь бол яг одоо юу дутагдалтай байгаа мэргэжлийн ажилтан байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлийн хөтөлбөрийг ер нь нэлээн ийм цогц хэмжээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.

2 дахь нь гаалийн албан татвартай холбогдолтой асуудал, асуулт асуулаа. 2023 оны 1 сарын 1-нээс самнах дамжлагаас дээших бүх тоног төхөөрөмжийг оруулж ирэхэд гаалийн албан татвараас чөлөөлөх энэ зохицуулалт хэрэгжээд явж байна. Хөрөнгө оруулалттай холбогдолтой ААН-үүд харьцангуй дотоодын болон гадаадын бас хөрөнгө оруулалтуудыг нэлээн авч байгаа. Энэ жил бас Итали болон Европын орнуудын томоохон үйлдвэрлэгч нар, гол тоглогч нар өөрсдөө Монголд бас үйлдвэрлэлүүдээ нээгээд ажиллаад явъя гэдэг энэ байдлаар бас ажиллаад явж байгааг энэ дээр нэмж танилцуулъя. Яг хөрөнгө оруулалтын зээл тусламжтай хамгийн чухал нэг асуудал нь бол барьцаа хөрөнгө баталгаа, үүнтэй холбогдолтой асуудал дээр нэлээн уян хатан бас зохицуулалтуудыг төрөөс бас хийж өгөхгүй бол санхүүжилт бол бид бүхэн бас жил болгон тодорхой хэмжээнд бол тавьж байгаа. Тэгэхдээ бүрэн бас түүнийгээ ашиглах хэмжээнд бол байж чадахгүй байгаа. Энэ нь бол одоо бид нарын тавьж байгаа гол шаардлагуудыг бас манай ААН маань хангахтай холбогдолтой асуудал байгаа юм. Тэгэхээр энэ дээр зээлийн батлан даалт болон тусгайлсан ийм бас арай хөнгөн ийм нөхцөлийг бас гаргаж ирэх бас шаардлагатай бас байгаа гэдгийг энэ дээр тодотгож бас хэлье.

**Г.Ганболд:** Энэ асуудлыг манай Байнгын хороо яагаад хэлэлцээд байгааг бол та бүхэн ойлгож байгаа шүү дээ. ЗГ дээр энэ 2 яамны байр суурь зөрчөөд байгаа юм. Салбарын яам буюу ХААЯ болохоор энэ зохицуулалтыг мөрдөх гээд байдаг, эсрэгээр нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр ойлголтын зөрөө

байгаа. Суурилуулагдсан хүчин чадал хүрэхгүй гэж үзээд байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг би Эдийн засгийн хөгжлийн яамны дарга нар байна уу? Энэ хүмүүс болбол Хүрэлбаатар сайдад одоо ч өөр мэдээлэл өгсөн байна лээ. Хүрэлбаатар сайд надтай уулзсан. Энэ ажлын хэсэгт орсон нөхдүүд яг энэ ажлын хэсгийн гаргасан дүгнэлттэйгээ яг санал нэг байгаа юу? Яг өнөөдөр 10 мянган тонн ноолуурыг угаах, самнах хүчин чадал Монгол Улсад яг байна уу? Энэнээс шалтгаалж өөрөө энэ чинь бас, бид нар чинь бас нэлээн эрсдэлтэй шийдвэр гаргах гээд байгаа хүмүүс шүү дээ. Хүчин чадал нь хүрээгүй байхад бид нар ингээд энэ зохицуулалтыг хэрэгжүүлээд эхлэх юм болбол ноолуурын үнэ буух эрсдэлтэй.

Хэрэв хүчин чадал нь хүрчихсэн байгаа болбол энэ өөрөө зөв шийдвэр болох гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол хэдүүлээ ингээд яг бүх талын байр сууриа нэгтгээд, энэ дээр Эдийн засгийн хөгжлийн яамныхан үнэхээр ингээд сая газар дээр нь үзээд, энэ хүчин чадал яг хангалттай байна гэж үзвэл та нар сайддаа зөв ойлголт өгөөд, энэ ЗГ дээр ядаж энэ сайд нар нь хоорондоо байр суурийн зөрөөгүй, энийг хэрэгжүүлээд явах ийм боломжийг олгох ийм шийдвэр гаргах гээд бид нарт нэг ёсондоо 2 сайдын хайнааг хагалж өгөх гээд байгаа хүмүүс шүү дээ бид нар. Тэр агуулгаараа болбол яг нарийндаа бол энэ маш том бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гаргасан юм. Бүх яамнуудаас хүмүүс оруулж. Тэгэхээр яг Эдийн засгийн хөгжлийн яамны энэ ажлын хэсэгт орсон 3 хүн яг тов тодорхой нэг хариулт өгөөдөх. Ажлын хэсгийн ажлын хэсгийн 4 номерын микрофоныг өгье.

**Б.Мөнх-Эрдэнэ:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Миний нэр Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого төсөөллийн хэлтсийн дарга. Ажлын хэсэгт манай газрын дарга орсон байгаа. Гэтэл нөгөө Орос Монголын ЗГ-ын комиссын хуралдаанд сайдад дуудагдаад

явчихлаа. Сая үйлдвэрүүдээр явж хүчин чадлыг тогтоох, тооцоолох, судалгаа хийх ажлын хэсэгт орж ажилласан. Бид нар нэг ажлын хэсэгт орсон юм чинь дүгнэлт дээр болбол тоног төхөөрөмжүүд бол суурилагдсан гэдэг дээр болбол санал нэг байгаа. Гэхдээ одоо бол саяын ажлын хэсгийн үр дүн дээр болбол түүнийг ажиллуулах ажиллах хүчин маань 8 мянга орчим ажиллах хүчин хэрэгтэй байтал одоо 4 мянга байна. Тэгэхээр 2 дахин нэмэгдүүлэх тэр орон зай хэрэгтэй юм биш үү гэсэн саналтай байгаа.

**Нөгөө талдаа бас компаниудаас хөндөж тавьсан асуудлууд байгаа. Ер нь энэ одоогийн техникийн зохицуулалт дээр болбол нөгөө угаасан ноолуурыг экспортлохыг хориглох тийм заалт байгаа. Тэгэхээр компаниудын, зарим компаниудын өгч байгаа мэдээллээр болбол заавал энийг хориглох шаардлага байна уу? Техникийн зохицуулалт нь өөрөө ингээд тодорхой бус байдлыг үүсгэх эрсдэлтэй байна. Ер нь компаниуд хүчин чадлаа суурилуулчихсан, ашгийн төлөө байгууллага учраас заавал техникийн зохицуулалтаар юмыг хориглож байж хөгжих нь зөв үү, буруу юу гэдэг дээр асуудал байгаа. Ер нь болбол угаасан ноолуурын экспорт жилдээ 250 сая ам.доллар орчим экспорт хийгддэг. Гэтэл нөгөө бүх хүний нөөц боломжоо тооцохгүйгээр хориглох шийдвэр гаргачихвал жилийн энэ 250 сая ам.долларын орлогыг алдах эрсдэл бол байгаа. Тэгээд Эдийн засгийн яам болбол одоогоор ийм тооцоололтой байгаа.**

**Г.Ганболд:** Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам болбол энэ ажлын хэсгийн дүгнэлтийг 100 хувь ямар ч гэсэн дотоодын 10 мянган тонн ноолуураа угаах, самнах хүчин чадал байна гэдгийг зөвшөөрлөө гэж ойлголоо шүү. Та нар битгий очоод тэгээд цаашаа сайддаа худлаа мэдээлэл өгөөд ингээд сайд нарын хооронд битгий зөрчил үүсгээд байгаарай. Саяхан би 3 хоногийн өмнө танай Эдийн засгийн хөгжлийн сайдтай уулзахад шал өөр мэдээлэлтэй явж байна

лээ шүү. Та нар өөрсдөө очоод ямар ч хүчин чадал байхгүй, бараг худлаа тэд гэж өгөөрэй гээд ам тоо өгөөд байна гэсэн мэдээлэл өгсөн байна лээ шүү дээ та нар. Одоо танай сайд бол яг тийм ойлголттой яваа. Тэгэхээр зэрэг би болбол ажлын хэсэгт орсон энэ Эдийн засгийн хөгжлийн яамны 3 нөхөр болбол яг албан ёсоор ингээд хүлээн зөвшөөрлөө гэж ойлголоо шүү. Тийм учраас танай сайд болбол энэ дээр өөрсдийнхөө хүмүүст та нар энэ мэдээллээ зөв очиж өгөөрэй гэдгийг би хэлэх гээд байгаа юм.

Тэгээд би ажлын хэсгийнхнээс зүгээр яах вэ нэг тэр 50 ААН-үүдээ жагсаагаад нэг хүчин чадлаар нь тавьчихсан болбол би жагсаагаад энэ тайландаа оруулчихсан байсан бол их зүгээр байсан юм. Жишээлбэл би энэ нэг ганц мэддэг юугаа асууя л даа. Өвөрхангайн Ноос ирээдүй гэж компани бий л дээ ноосны. Тэр бол ноос л угаадаг юм 4000 тонн. Тэр яг ноолууран дээр наад дүгнэлтэд чинь хэд гэж орсон байна вэ, надад нэг хэлээд өгөөч. Тэгээд би бас нэг ганц нэг мэддэг юмаараа бас нэг жишээ авч үзье л дээ. Яг хэдэн тонноор орсон байна вэ, тэр бол ноос л угаадаг үйлдвэр. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

**В.Болормаа:** ХХААХҮЯ-ны ахлах мэргэжилтэн Болормаа байна. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өвөрхангай аймгийн Ноос ирээдүй компанийн суурилагдсан хүчин чадал бол 100 тонн гэж өгсөн. Үүнээс бол 70 хувьд нь буюу 7 мянган тонн дээрээ бид нар ноолуур самнах боломжтой, боломжтой гэсэн ийм тоо хэмжээг өгсөн байна. 70 тонн, 70 тонн. 70 тонн шүү тийм.

**Г.Ганболд:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн байхгүй байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад тогтоолын төсөл дээр асуух асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна. Тэмүүлэн гишүүний гаргасан, зарчмын зөрүүтэй санал гаргасан билүү? Тэмүүлэн гишүүн

гараагүй юу тийм ээ? Зарчмын зөрүүтэй, яах вэ зүгээр ер нь Тэмүүлэн гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Энэ 24 оны намрын ээлжит чуулган гэдэг бол дараагийн Их Хурлын бүрэн эрхийн асуудал болоод явчхаж байгаа юм. Уг нь бол энэ тогтоолын төслөө хэдүүлээ яг энэ бүрэн эрхийн хугацаанд нэг сонсъё гэвэл 24 оны хаврын чуулган болгож болох бололцоо бол байгаа л даа. Тэгээд энэ дээр зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас тогтоолын 1 дүгээр заалтаар болбол энэ худалдааны техникийн зохицуулалтыг мөрдүүлэх гэдэг агуулга нь болбол 24 оны 7 сарын 1-нээсээ мөрдүүл гэдэг энэ агуулгаар гарч байна гэж ойлгож байна тийм ээ, тийм. Тэгэхдээ болбол тэр агуулгаар нь ойлгохгүй бол тогтоолын 2 заалт бол нэлээн л мөлгөр л юу байна л даа.

Тогтоолын төсөл дээр асуулттай, саналтай гишүүн байхгүй байна. Тэгэхээр тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66,7 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа. Ажлын хэсэгт баярлалаа.

11.15 цаг

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/**

Дараагийн асуудалд оръё. Дараагийн асуудал Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад ажлын хэсэг, ажлын хэсгийг оруулъя. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад ажлын хэсгийг танилцуулъя. Д.Энхболд Аудитын ерөнхий газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Б.Саруул Аудитын менежер, Батдэлгэр ахлах аудитор, Г.Жавхлан ахлах аудитор, Будбаяр Тавантолгой төмөр зам компанийн гүйцэтгэх захирал, Болор-Эрдэнэ Төслийн газрын захирал, Н.Мөнхсүрэн Хяналт шинжилгээ, дотоод аудитын албаны дарга,

Б.Отгонсүх МТЗ компанийн гүйцэтгэх захирал, Г.Өлзийбаяр Санхүүгийн хэлтсийн дарга, Х.Батсайхан Зэвсэгт хүчний Барилга инженерийн удирдах газрын дарга, хурандаа, Д.Энхцог ерөнхий инженер, Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа, Ц.Баяргэрэл Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа, Х.Мөнхжаргал ЭТТ компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Г.Гантулга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга гэсэн ажлын хэсэг байна.

Өнгөрсөн долоо хоногийн Байнгын хорооны хурлаар Тавантолгой, Тавантолгой-Гашиунсухайт, Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төсөлд хийсэн Аудитын газрын тайланг сонсоод, тэгээд тухайн асуудлыг зарим нэг зүйлийг тодруулах зорилгоор асуудлыг хойшлуулсан. Энэтэй холбогдуулаад Аудитын ерөнхий газраас Байнгын хороонд тайлбар ирүүлсэн. Тодорхой мэдээллүүдийг нэгтгэж 1км авто зам ямар өртөгтэй байх вэ гэдэг дээр бол тодорхой мэдээллүүдийг бол ирүүлсэн. Тийм учраас бид нар болбол нэмж аудитын сэдэв өгөөгүй учраас энэ асуудалтай холбогдуулаад ЗГ-т чиглэл өгөх тухай энэ тогтоолын төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад уг аудитын байгууллагын гаргасан дүгнэлтээр энэ Тавантолгой МТЗ компани дээр үүсээд байгаа өр авлага мөн ЭТТ компаниас энэ өр авлагыг барагдуулахтай холбоотой, энэ ЭТТ хүмүүс ирээгүй юм уу? ЭТТ, ядаж захирал нь биш юм аа гэхэд цуг байгаа хүмүүсийг нь оруулах хэрэгтэй байна. Тэднийхтэй холбоотой энэ тогтоолын төсөл дээр хэд хэдэн заалтууд байгаа. ЭТТ-н хүмүүсийг орж, одоо ирж байна гэнэ. Орж ирэхээр нь ЗГ-ын хуралдаан давхцаад байгаа юм байна. Орж ирэхээр асуултаа асуугаад явъя. Эднийх ингээд байгаа юм. Би энэ тогтоолын төсөл дээр 2, 3 заалт оруулчихсан юм. Энэ Отгонсүх захирал эд нар харсан болов уу? Эднийх нөгөө энэ Тавантолгой Зүүнбаян төмөр замыг барихтай холбогдуулаад энэ МТЗ



компани дээр их хэмжээний өр төлбөр үүсчхээд байгаа юм байна лээ ААН-үүдэд. Тэгээд энийг барагдуулах чиглэлээр би Тавантолгой компанийн удирдлагуудаас бас яг асуух гээд байгаа юм. Тэгээд энэ дээр зүгээр 2 заалт, хэн ээ энэ 45-ыгаа хасаагүй юм уу? Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Асуулттай гишүүн алга. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Асуулт, үг тасалъя. Батжаргал гишүүн асуулт асууя. Үг хэлэх юм байна. Батжаргал гишүүн үг хэлье.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр тогтоолын төслийн ерөнхий агуулгыг дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ өнөө төмөр замын бүтээн байгуулалтын ажлын санхүүжигч тал нь ЭТТ, захиалагч гүйцэтгэгчүүд энэ хоорондын хийсэн гэрээ бүх юмыг үндэслээд энэ үүссэн өр төлбөрийнх нь асуудал яг аль талдаа дагаж ишлжих ёстой юм гэдэг юмаа жсоохон нягтлах ёстой байсан болов уу л гэсэн миний санаа байгаад байгаа юм. Бас тодорхой хэмжээний энэ чинь хүний хөрөнгөөр хийчихсэн төмөр замыг ашиглаж байгаа учраас түүний орлого, түүнээс бий болсон өгөөж дээр тулгуурлаж эргэн төлөлтийн асуудал байхыг үгүйсгэхгүй л дээ. Би бол тэгж бодоод байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг нэгэнтээ төмөр зам нь ЭТТ-доо биш төмөр замдаа очиж байгаа юм бол тэр байгуулагдаж байгаа компани нь энэ хоёрын хоорондын өнөө хөрөнгийн оролцооны хувь гэдэг юм уу, хувьцааныхаа зарчмаар юу, яах бололцоо бий юү гэж, тийм л санаа байгаад байгаа юм л даа. Тэгэхээр зэрэг энийг нэг нягтлах ёстой юу, үгүй юү?

**Г.Ганболд:** Энэ дээр 2 өр төлбөрийн асуудал байгаа та мэдэж байгаа тийм ээ. Тэгэхээр эхний 67-гийн хувьд болбол тухайн төсөлд зарцуулах санхүүжилтээс Зэвсэгт хүчний нэгтгэлүүдэд нөгөө техник аваад өгчихсөн. Тэгэхээр энийг болбол одоо заавал бид нар ЭТТ-гоос ч гэдэг юм уу ийм байдлаар бол оруулаагүй л дээ. Энийг

ямар ч гэсэн одоо зэвсэгт хүчний тэр техникийг аль нэгэн эх үүсвэрээс санхүүжүүлэх замаар цаана нь МТЗ-аас өр, үгүй, өр авлага нэхэж байгаа ААН-үүдийн тэр өр төлбөрийг барагдуулах л чиглэл өгч байгаа юм. Тэгэхээр ямар ч гэсэн энийг ЗГ-т чиглэл өгөхөөр эд нар болбол ямар ч гэсэн гарц гаргалгаагаа олж, дараагийн 51-ийн хувьд болбол яах вэ МТЗ бол үгүй ээ ЭТТ компани бол өгөхөд бэлэн, эргэн төлөлтийнхөө хуваарийг батлаад ингээд явах юм бол төлье л гэсэн ийм агуулгатай байгаа учраас энэ тогтоолоор бид нар энэ ААН-үүдэд нь ЭТТ компанид үүрэг чиглэл өгөөд, тэгээд би уг нь өнөөдрийн хурал дээр дуудсан, ЗГ дээр яг асуудал нь танилцаж, давхцаад байна. Тэгээд яг энийг ямар хугацаанд барагдуулах боломжтой вэ гэдгийг нь уг нь асууж байж бас энэ тогтоолын төслийг баталъя гэж ингэж бодож байсан юм.

Асуулт асуух гишүүн байсангүй. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байхгүй. Тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66,7 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад энэ холбогдох байгууллагууд, бид нар энэ ЗГ-т чиглэл өгөх тухай тогтоол гаргасан. Энэ тогтоолын дагуу энэ өр авлагыг барагдуулах тал дээр энэ ТӨК-уд, энэ Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд бас энэний дагуу шаардлагатай арга хэмжээ авч, тэр ААН-үүдийн өр авлагыг барагдуулах тал дээр онцгой анхаарал хандуулж ажиллахыг хүсэж байна. Ингээд тогтоолын төсөл батлагдсанаар өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дуусаж байна. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

11.28 цаг

Хуралдаан  
мэдэгдье.

өндөрлөснийг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

